**ОРХОН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 08 -ны өдөр Дугаар А/71 Эрдэнэт

Эмнэлгийн тусламж үйлчилгээний
бэлэн байдлыг ханган ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 52.1, 76.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Журам батлах тухай" А/611 дүгээр тушаал, 2021 оны 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үндэсний их баяр наадмын өдрүүдэд Коронавируст халдвар /COVID-19/-ын болон эмнэлгийн бусад тусламж үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах, шуурхай арга хэмжээ авах зорилгоор 2021 оны 07 дугаар сарын 10-ний өдрөөс эхлэн 2021 оны 07 дугаар сарын 19-ны өдөр хүртэл ажиллах хариуцлагатай жижүүрийн нэрсийг 1-р хавсралтаар, үндэсний их баяр наадмын өдрүүдэд эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах хуваарийг 2-р хавсралтаар тус тус батлсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагууд баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилж, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган, коронавируст халдвар /COVID-19/-ыг илрүүлэх тандалт,шинжилгээ,дархлаажуулалт,гэрийн эмчилгээ хяналтыг үргэлжлүүлэн, батлагдсан тохиолдолд эрэмбэлэн ангилалтыг зөв хийж шатлалын дагуу тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулж, хүндэрсэн өвчтөнг цаг алдалгүй шилжүүлж ажиллахыг салбар байгууллагуудын /Дарга, Захирал/ нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагууд АМ-36, АМ-33 маягтын дагуу өдөр бүр 07:30, 21:00 цагт Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт мэдээлэх, нэгтгэсэн мэдээллийг аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, Эрүүл мэндийн яаманд мэдээлж, нийтийг хамарсан хордлого, осол гэмтэл, халдварт өвчний дэгдэлт болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой цаг үеийн мэдээллийг хугацаа хоргалзахгүй удирдлагуудад танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгосугай.

4. ЭМГ-ын хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдад илүү цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бодож олгохыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Эх хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан /П.Хишгээ/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 07 дүгээр сарын
08...-ний өдрийн А/77 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Үндэсний их баяр наадмын өдрүүдэд ажиллах хариуцлагатай
жижүүрийн нэрс, хуваарь

| д/д | Албан хаагчийн овог нэр | Албан тушаал | Жижүүр хийх өдөр | Харилцах утасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Т.Нарантуяа | Уламжлалт анагаах ухаан сэргээн засах тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан ажилтан | 2021.07.10 | 9912-6635 |
| 2 | Б.Байгаль | Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн | 2021.07.11 | 9935-2667 |
| 3 | А.Баярхүү | Сувилахуй болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | 2021.07.12 | 9936-8309 |
| 4 | П.Хишгээ | Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | 2021.07.13 | 9935-9900 |
| 5 | Ө.Наранзаяа | Эрүүл мэндийн боловсрол сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтан | 2021.07.14 | 95545509 |
| 6 | А.Баярхүү | Сувилахуй болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | 2021.07.15 | 9936-8309 |
| 7 | П.Хишгээ | Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | 2021.07.16 | 99359900 |
| 8 | Т.Нарантуяа | Уламжлалт анагаах ухаан сэргээн засах тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан ажилтан | 2021.07.17 | 99126635 |
| 9 | Г.Итгэл | Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн | 2021.07.18 | 99967736 |

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 07 дугээр сарын
08-ний өдрийн А/31 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ӨДРҮҮДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛЛАХ ХУВААРЬ

| № | Байгууллагуудын нэр | VII/10 | VII/11 | VII/12 | VII/13 | VII/14 | VII/15 | VII/16 | VII/17 | VII/18 | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | БОЭТ | + | + | + | + | + | + | + | + | + | 24 цагаар эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. |
| 2 | Тусгаарлах эмнэлгүүд /Ачит, Талын булаг, Бадархундага, МСҮТ/ | + | + | + | + | + | + | + | + | + | 24 цагаар эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. |
| 3 | Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүд | + | + | + | + | + | + | + | + | + | 1.Үндсэн үйл ажиллагаа 10.00-14.00 цаг<br>2.Батлагдсан тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэх, хавьтлын шинжилгээ авах 09.00- 18.00 цаг<br>3.Дархлаажуулалтын үйл ажиллагааг 8 өрхийн эмнэлэг нэг өдрөөр ээлжлэн хариуцаж зохион байгуулна.<br>10.00 – 17.00 цаг |
| 4 | НЭМТ-ийн Вирусологийн лаборатори | - | - | - | - | + | + | + | + | + | 12.00 -18.00 хүртэл ажиллана.<br>Өдөрт ЭМГ –аас 96 ПГУ шинжилгээ хүргүүлнэ. |
| 5 | Эрдэнэт сувилалын цогцолборын вирусологийн лаборатори | + | + | + | + | - | - | - | - | - | 12.00 -18.00 хүртэл ажиллана.<br>Өдөрт ЭМГ –аас 96 ПГУ шинжилгээ хүргүүлнэ. |
| 6 | Сайн дурын шинжилгээний цэг / Барилгачин/ | + | + | + | + | + | + | + | + | + | Өдөр бүр 08.00 – 12.00 хүртэл ажиллана |
| 7 | Сайн дурын шинжилгээний цэг / Наадмын талбай / | + | + | + | + | + | + | + | + | + | Өдөр бүр 10.00 -17.00 хүртэл ажиллана. |
| 8 | Явуулын амбулатори | + | + | + | + | + | + | + | + | + | Өдөр бүр 10.00 -17.00 хүртэл ажиллана |
| 9 | Медипас эмнэлэг | - | - | - | - | - | - | - | - | - | Багаж тоног төхөөрөмж, программын техник засвар үйлчилгээтэй тул ажиллах боломжгүй. |
| 10 | Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд | + | + | + | + | + | + | + | + | + | 24 цагаар ажиллана. |
| 11 | Эмийн сангууд | + | + | + | + | + | + | + | + | + | Орхон сөд, Энэрэх заяа, Мөнхалтаргана эмийн сангууд 24 цагаар, бусад эмийн сангууд 09:00-23:00 хүртэл ажиллана. |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Шуд холбоо | - | - | - | - | - | + | + | + | + | Ажлын 8 цагаар ажиллана. |